



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ДАДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 03 өдөр

Дугаар 182

Баян-Овоо

Шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх  
хаврын дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.11, 59.1.12, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны A/165 дугаар тушаал, аймгийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн A/297 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчинөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг сумын хэмжээнд бүх үхэр, гахайг хамруулан 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрөөс эхлэн 2024 оны 06 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл хугацаанд шуурхай зохион байгуулсугай.

2. Малчдад урьдчилан сэргийлэх талаар мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн урьдчилан сэргийлэх тарилгад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангаж ажиллахыг Мал эмнэлгийн тасгийн дарга (С.Мөнх-Эрдэнэ), “Галтай сүрэг” ХХК-ийн малын эмч (Д.Хувьтай), “Тэнгэлэг гол” ББН-ийн малын эмч (Б.Болормаа), багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

3. Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлсхийсэн малчид, мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн албан тушаалтанд холбогдох хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг мал эмнэлгийн тасгийн дарга (С.Мөнх-Эрдэнэ), багийн Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.МӨНХ-ОД

010000213